

ШАШНЫ АГУУЛГА БҮХИЙ ШИДЭТ ҮЛГЭРИЙН ТУХАЙ

Товч агуулга: Монгол ардын шидэт үлгэрийн хамрах сэдэв, агуулга маш баялаг, түүхэн цаг хугацааны тусгал болон хөгжсөөр ирсэн байдаг. Хэдийгээр ард түмний уран сэтгэмжлэл, хийсвэр сэтгэлгээний үр шим мөн боловч түүнд ямар нэг хэмжээгээр эртний сэтгэлгээ, зан заншил, шашин шүтлэг, ахуй байдал тэдгээрээр дамжин илэрч байгаа ард түмний хүсэл эрмэлзлийг тусгаж байгаагаараа үлгэр маш сонирхолтой бөгөөд цаашид чухал судалгааны объект болсоор байх нь илэрхий. Монгол ардын аман зохиолын төрөл зүйлс шашны нөлөө, түүний янз бүрийн нэр томъёог тусгасаар ирсний жишээ мөн шидэт үлгэрт илрэлээ олжээ. Бурхны шашны холбогдолтой иймэрхүү зүйлс нэн ялангуяа баатарлагийн үлгэрт илүү тохиолдох ажээ. Ер нь буддын шашны өнгө аяс сонгодог шидэт үлгэрийн уламжлалт өгүүлэмжтэй хослон бий болсон шидэт үлгэрүүд олон байдаг.

Түлхүүр үг: шидэт үлгэр, бурхны шашны нэр томъёо, ойлголт, шилжмэл өгүүлэмж, баатарлаг үлгэр.

Baasanjargal Dairiima

The Institute of Language and Literature of the Mongolian Academy of Sciences
Ulaanbaatar, Mongolia

ABOUT FAIRY TALES WITH RELIGIOUS CONTENT

Abstract: The Mongolian tales is diverse in content, has an oral and written origin. Since ancient times, Mongolian tales have interacted with tales of other peoples at the level of story, artistic imagery, structure and ideas. Some Mongolian fairytales, originate from India and Tibet, which is connected with the spread of Buddhism in Mongolia and the great role played in this process by the translation of canonical Buddhist writings. Indo-Tibetan origin has such well-known in Mongolia fabulous cycles, as ‘The magic deadman’, ‘Stories from Pancatantra’, ‘Tales of Raja Burdzi’. All of them carried the preaching of ideas of Buddhism.

Keywords: canonical writings, fairytale, interactions, wandering plot, idea, Buddhist literature.

Монгол соёл дахь энэтхэгийн нөлөөг төв азийн нүүдэлчдийн дунд буддизм анх дэлгэрсэн үетэй холбон үздэг. Ялангуяа буддын шашин сургаалын ном бүтээлүүд орчуулагдаж эхэлсэн XIII зууны үеэс шинэ мотив өгүүлэмж нэвтрэн жинхэнэ монгол ахуйд идээшиж, монгол сэтгэлгээгээр хувиран үндсэн монгол аман зохиолын жишээ мэт болсон байдаг. Академич Ц. Дамдинсүрэн “Монголын уран зохиолын тойм” (XVII-XVIII)-ын хоёрдугаар ботид янз бүрийн улс түмнүүдийн дунд дэлгэрсэн тэнгэрийн дагинын үлгэрүүдийг харьцуулан нэгэн үлгэрийн олон хувилбарууд байх магадлалтай гэж үзээд “... Үлгэрийн сэдэв өгүүлэгдэхүүнийг зээлдэн авах, уламжлан авах онолоос гадна, төстэй нөхцөл байдалд төстэй сэдэв өгүүлэгдэхүүнтэй үлгэр бий болдог онол бас байна. Тиймээс зүй зохисын дотор, хир хэмжээнд нь тааруулж, тодорхой баримт дээр тулгуурлаж хэрэглэх хэрэгтэй” [Дамдинсүрэн, 1977] хэмээн харьцуулсан судалгаа хийхдээ дээр маш ул суурьтай хандах ёстойг сануулсан байдаг. Түүнчилэн “...нэгэн ард түмний дотор байгаа үлгэр нь нөгөө ард түмний доторх үлгэртэй төстэй байлаа ч гэсэн нэгэнт тэр ард түмний дунд дэлгэрсэн бол тэр нь тэр ард түмэнд харийн юм биш, өөрийн юм болно” хэмээн онцлон тэмдэглэжээ. Монгол ардын шидэт үлгэрээс гадна адгуусан амьтны үлгэрт *хулгай худал хоёр хэзээд мэдэгдэнэ, худгийн мэлхий далайн хэмжээг үл мэднэ* гэх зэрэг сургаал үг, зүйр үгээр төгссөн үлгэрүүд их тохиолдох бөгөөд тэдгээрийн олонх нь монгол ахуй, сэтгэлгээ нэвт шингэсэн энэтхэг-төвдийн Панчатантра зэрэг бичгийн зохиолын хэрмэл өгүүлэмж бүхий үлгэрүүд байдаг. “Эвтэй дөрвөн амьтан”, “Яст мэлхий”, “Муур багш”, “Хоёр сайн морь”, “Сармагчин, мэлхий хоёр” зэрэг ёс суртахууныг номлосон үлгэрүүд үүний тод жишээ болдог билээ. Ер нь Панчатантрагийн ёгт үлгэрүүдийн өгүүлэмж дэлхийн маш олон оронд тархсан бөгөөд, түүгээр ч барахгүй Евро-азийн ард түмнүүдийн дунд тархсан үлгэрүүдийн адил төст өгүүлэмж, мотивууд нь “Панчатантра”-гаас эх сурвалжтай гэсэн “хэрмэл өгүүлэмж”-ийн онолыг XVIII зууны үед боловсруулснаар утга зохиолын судлалд өргөн дэлгэрсэн “зээлдлэгийн онол” үүсч бий болсныг бид бүхэн мэднэ.

Түүнээс гадна цаг хугацаа өнгөрөхийн хэрээр үлгэрийн агуулгад өөрчлөлт орж ард түмний бурхны шашны ам дамжсан домог, яриа сэлтээс шидэт үлгэрт оруулан ярьж эхэлсний жишээ болсон үлгэрүүд монгол мөн шидэт үлгэрийн өгүүлэмжийн санг бүрдүүлэх болжээ. Үлгэрийн хөгжил хувьслын гол хүчин зүйл болсон нийгмийн өөрчлөлт, элдэв үйл явц нь шидэт үлгэрт ч тод томруунаар тусгалаа олсон байдаг. Энэ төрлийн агуулга бүхий шидэт үлгэрийн өгүүлэмжээс харахад нэлээд эртний үедээ яригдаж байсан үлгэрт

дундаас нь бурхны шашны домог, хуучийн мотив хавчуулагдсан шинжтэй ажээ. Монгол ардын аман зохиолын төрөл зүйлс шашны нөлөө, түүний янз бүрийн нэр томъёог тусгасаар ирсний жишээ мөн шидэт үлгэрт илрэлээ олжээ.

Бурхны шашны нөлөөг тусгасан олон шидэт үлгэрийг ажиглавал ихэнхдээ баатарлагийн сэдэвтэй шидэт үлгэрт тохиолдож байна. Тухайлбал, “Наран Довчин хааны үлгэр”-т “*Тэр хааныд бас нэг ижийн үед байгуулсан эрдэнэ зуугийн ганжууртай, аавын үеэс байгуулсан алтан зуугийн ганжууртай байлаа*” гэх буюу хаан мангастай дайтахаар мордохдоо хатандаа “*Гайгүй, гайгүй. Ламаараа ганжуур, данжуур хуруулж байгаарай. Зүгээр, зүгээр. Ламаараа зундуй, жадамба хуруулж байгаарай. Чавганц нарыг цуглуулан тахил, дээж өргүүлж байгаарай. Хүүхдүүдийг цуглуулаад хүрэн модоор гүвдүүлж байгаарай гэж хэлээд эргүүл, түшмэд хоёул явж болзоотын ууланд очоод...*” гэх мэтийн дүрслэл байх бол “Анаа мэргэн хаан” үлгэрт баатарлагийн туульсад гардгийн адил “*Нэгэн өдөр Анаа мэргэн хаан Алтай сүмбэр ууландаа гарч 13 сангаа тавиад сүр жавхлан бадруулж, сүлд заяагаа даллаад...*” гэж эхэлдэг.

Академич Х. Сампилдэндэв “Монголчуудын үгийн урлагийн эх болсон аман зохиол эрт үеэс эдүгээг хүртэл уламжлагдахдаа шүтлэгийн эртний хэлбэрүүд бөө мөргөл, бурхны шашны нөлөөг шингээн хувьссаар ирсэн юм” хэмээн тэмдэглээд “аажимдаа монгол туулийн баатруудыг бурханчлан үзэж, ямар туулийг ямар үед хэлэх вэ гэх зэргээр зан үйлийн шинжийг олсоор ирсэн, баруун монголын туульчдын нэлээд нь лам байсныг дурдаж ертөнцийг тойрч Буддын шашны дайсныг дарж явдаг Лхам бурхны домог нь Алтайн урианхайчууд туульдаа Буддын шашны нөлөөг оруулах үндсийг тавьж өгсөн байж магадгүй” [Сампилдэндэв, 2004, 66 т.] хэмээн тэмдэглэжээ.

Энэчлэн, шидэт баатарлагийн үлгэр дэх бурхны шашны янз бүрийн нэр томъёо, ойлголт үлгэрийн эхэнд голдуу таарах баатрын болоод түүний эд эдлэл, эхнэр хатны магтаал зэрэгт илрэлээ олсон байна. Эдгээр нь дээр өгүүлсэнчлэн туулиас уламжлан яригдсаар шидэт баатарлагийн үлгэрийн шинжийг олсны жишээ бөгөөд монгол шидэт үлгэрийн түгээмэл, эртний гэж хэлж болохоор мотив ажиглагдана. Тухайлбал, “Хээр цоохор морьтой Хэлбэс бүүтэр баатар” хэмээх үлгэрт “*баатар хатан буулгаж ирэхээр мордохдоо эгчдээ нэгэн суврагыг зааж миний бие эрүүл мэнд, бүрэн бүтэн байвал энэ суварга бүтэн байна. Элдэв саад бэрхшээл тохиолдож хөнөөгдвөл суварга эвдрэх болно*” гэж өгүүлээд алсын аяндаа морджээ гэж гардаг. Монгол ардын үлгэрт заримдаа “хол замд одох” мотив ямар нэг эд зүйлээр хувь заяагаа шинжих өгүүлэмжтэй зэрэгцэж явдаг. Аж байдлын нэгэн үлгэрт ах дүү гурав салж одохдоо барьж байгаа гурван модоо газарт хатгаад гурван тийш явж гурван жилийн дараа эргэж үзэхэд ямар ургаснаар нь хэн хэнийхээ хувь заяаг шинжих болзол тавиад тарцгаадаг. Гурван жилийн дараа дунд ах нь айлд зарцлагдан дөнгөн данган амь зууж байгаад ирэхэд нь их ахынх нь мод хатаж унаад хугарсан, өөрийн нь мод муухан өнгөгүй, дүүгийн мод хамгийн сайхан ургасан байхыг үзэж ахыгаа үхсэнийг, дүүгээ сайн явааг мэдэж нэг улсын хаан болсон байхад нь очиж уулзан амар сайхан жаргаснаар үлгэр төгсдөг.

“Арван таван настай охинтой эмгэн өвгөн хоёр”¹ үлгэр “*Эрт урьд арван таван настай, тарган улаан хүүхэнтэй эмгэн өвгөн хоёр аж төрөн амьдарч байжээ. Гэрийн хойноос суварганы толгой цухуйж, өвгөн эмгэн хоёр түүнд залбиран элбэг хангалуун амьдарч байж. Хүүхэн өдөр бүр зургаа, долоон ямаагаа хариулж явдаг гэнэ. Нэг удаа шовгор малгайтай лам хүрч ирээд хүүхнээс бадар барихад долоон ямааныхаа хамгийн сайныг барьж өгчээ*” гэж эхэлдэг. Энэ үлгэрийн үйл явдал суварганд хүүхэндээ нөхөр гуйн залбирснаар мангас түүнийг нь сонсоод хүүхнийг нь мэхлэн авч байгаа өгүүлэмжээр үргэлжилнэ. Цааш мангас хүүхэн хоёрын зөрчил эхлэх ба шидэт туслагч болох ламын тусламжтайгаар охин мангасаас ангижирч байгаа өгүүлэмжтэй. Тэр өвгөн хүүхэнд туслахаар ирэхдээ “*Чи энэ ямааг таньж байна уу гэжээ. Танилаа гэхэд нь, - Чи гурван эрдэнэдээ үнэнч, эцэг эхээ сайхан тэтгэж өргөсөн хүн. Би далха таван тэнгэр гэгч байна. Намайг бадарчин болоод явахад чи үнэн сэтгэлээс энэ ямааг өгсөн шүү дээ. Чамд хэдэн тэмээ алт, мөнгө өгнө. Энэ байгаа юм бурхны чадлаар бүтсэн болохоос биш бүгд хоосон*” хэмээн өгүүлдэг. Энэ мэтчилэн буддын шашны өнгө аяс сонгодог шидэт үлгэрийн уламжлалт өгүүлэмжтэй хослон бий болсон шидэт үлгэрүүд олон байдаг.

Бурхны шашны ойлголт шидэт үлгэрийн элементүүдтэй сүлэлдэн бий болсон нэг үлгэр бол “Ороолон”² хэмээх үлгэр юм. Тэр үлгэрт араар дүүрэн ай түмэн адуутай, өврөөр дүүрэн үй түмэн адуутай нэг их баян хааны сайхан хүү нь адуугаа хураах гэж өдөрт арван хүн морддог, тэдэн дунд хамт мордолцдог байж. Тэгээд ойд нэгэн сайхан эхнэртэй таарч нөхцөөд гэртээ ирсэнгүйд баян аав нь өөрөө мордож тэр эхнэртэй нь хамт авч ирнэ. Төдөлгүй хүүгийн аав, ээж бэрийгээ шулам гэдгийг мэдээд “*Хүүгийнхээ амийг бодъё. Баруун*

¹ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн гар бичмэл эх хэрэглэгдэхүүний хөмрөг №2. Дансны товъёгийн №56, Хадгаламжийн нэгжийн № 18.

²ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Дуун ухааны сан хөмрөг. Хавтас-2.

зуугаас наахна биеэрээ ямандаг бурхан болж байгаа нямба хийсэн тийм айхтар хүн бий. Тэрэнд очиж учраа хэлбэл хүү минь амь гарах магадгүй, бидний үхэх сэхэх нь хамаагүй гэжээ. Тэгээд ай түмэн адуундаа байх хоёр сайн хүрэн мориог хэлийг нь хялгасаар даруулж долоо хоног сойгоод хүүгээ дуудуулж, -За, чиний амь гарах аргыг хэлж өгье гээд нөгөө сайн хүний байгаа газрыг хэлээд, -Мориноосоо бууж огт болохгүй, шээсэн ч мориноосоо шээж, идсэн ч морин дээрээ идэж яваарай гэж захижээ. Тэгээд эцэг эх нь гурван хэрэг болох зүйлийг өгчээ. Хаан, -Миний урд урдын хаадын эрдэнэтэй билүү бий. Тэрнийг өвөртөө хийж яваад дайсан ирвэл “гэтэлж гаршгүй хар хад бол” гээд хаяарай. Тун аргагүй болбол шүтээн жадамбыг хаяарай. Үсгийн тоогоор дайсны хүч суларна гэв. Хатан эх нь, - Эрдэнийн самыг минь авч яв. Дайсан ирвэл “амьтан хүн гэтэлж гаршгүй шивээ мод бол” гээд хаяарай гэж” захиад явуулахад шулам эхнэр нь хичнээн хол явсан ч агшин зуур чамайг гүйцнэ шүү гээд үлдэнэ. Хүүг ирэхгүй удсанд нөгөө шулам эхнэр хилэгнэн баяны гэрийг нар буруу гурав эргэн, баруун урд өвсөн дээр очиж хөрвөөнгүүт нэг их урт хөх чоно болчихоод, – “Та нарыг буцаж ирж үгүй хийнэ. Нөхрийнхөө хойноос яарч байна гээд гал манан татуулан арилжээ”. “Хүү явж байгаад эргээд хартал тоос гэхэд тоос ч биш, гал гэхэд гал ч биш нэг юм харагдаж гэнэ. Ихэд айж нөгөө билүүгээ чулуудтал нэг их хад болжээ. Тоос ч харагдахаа байж. Явж байгаад дахиад эргээд хартал өнөөх тоос бас босч харагдана. –Ээжий, амь авар! гээд саама хаячихаж. Амьтан хүн гаталж гаршгүй нэг их шивэр ой болж хувирчээ. Тоос ч дарагдаж. Тэгтэл нэг агуйтай хад харагдсанд, - Лам амь авар! гэж бахирчээ. Тэгтэл нэг их үстэй хүн гарч ирээд, -Чи манайд орж болохгүй. Цаанаас чинь ороолон ирж яваа гээд өврөөсөө ном гаргаж өгөөд баруун зуугийн гэгээнтнийг зааж өгөөд явуулж гэнэ. Хүү шар хэрэмд ойртож ирээд эргээд хартал тоос босч харагдахаар нь хүү алтан жадамбыг задалж хаяжээ. Агаараар нисч явсан ороолон тэр номын үсэг тоолон бүдрээд хойноос нь хөөгөөд байжээ. Гуядаж үзээгүй морио гуядан шар хэрэм дээгүүр харайх гэтэл өнөөх чинь морины нь охор сүүлэн дээрээс бариад авчээ. Ламын өгсөн өөрийн номоор тархин дундуур нь нэг буулгаад шар хэрэм даваад орчихож. Хэрэм дотор байсан дуганы лам нар номын хүчээр ороолонг дараад, хүү ч нутагтаа буцан амар сайхан жаргаж гэнэ” хэмээн төгсдөг. Шидэт үлгэрийн баатар ямар нэгэн шидэт туслагчийн хүчээр эсрэг баатрыг ялан дийлж байдаг бол энэ үлгэрт лам нарын уншсан номын хүчээр ороолонг дарж байна. Эндээс бид шашны ойголтой зэрэг гарч ирсэн чөтгөр, шулам, ороолон гэх зэргийн тухай хууч яриа, домог мэтийн зүйлс шидэт үлгэрийн элементүүдтэй нийлэн буй болсон аман зохиолын төрөл зүйл хоорондын өгүүлэмж, мотивын шилжилт, хувьслыг харж болох юм.

Дээрх үлгэр номын хүчээр ороолонг дарж буй агуулгатай бол “Анчин хүү” хэмээх үлгэрт шулам авгай өөрийн хүчээр дарсан хүүгийн тухай өгүүлэмж бас байна. Тухайлбал, шуламсаас дутааж ирсэн хүүгийн бие их тавгүй байсанд эцэг нь “За хүү минь тэр чинь тун айхавтар юм байжээ. Чи өнөө шөнөдөө хоноод маргаашдаа багтаж буцаж очоорой. Тэгэхдээ сайн мориор яв. Очоод нэг хоёр хоноод нэг өглөө орноосоо босолгүй бие муу байна үхэх цаг болжээ гэж хэлээд хэвтээд бай. Тэр шулам эм юу тус болдог юм бол гэж хий дэмий нэг зовлон болох байх. Тэгэхээр нь миний өвчин тун хэцүү хүнд юм аа. Жамсран бурхны сахлаар утвал жаахан гайгүй болдог юм гэж хэл. Түүнийг авах гэж явбал догшин бурхан түүнийг нэг дарж мэднэ. Хэрэв аваад ирж чадвал махгал бурханы сормуус авч ир гэж хэл. Түүнийг аваад ирвэл Чойжээ Лхамын үүдэн дээр байгаа гурван алтан шүхрийг булга татаад ир гэж явуул. За тэгээд тэр гурвыг авч ирж чадвал чи дуусч байгаа нь тэр. Түүнээс өөр түүнийг дарах юм байхгүй. Хэрэв тэр хооронд дарагдвал яахав чи амьд гарч болох юм гэж хэлж явуулжээ” гэж гардаг. Хүү эцгийнхээ хэлснээр хийсэн боловч Жамсран бурхны сахал, махгал бурхны сормуус, Чойжоо Лхамын үүдэн дээр байгаа гурван алтан шүхрийг авчирхаар яваад бурхдад дарагдсангүй бүгдийг олж ирэхэд манай эцэг эх дээр очиж амьдаръя хэмээн худлаа хэлж дагуулан явах зуур өөрөө түрүүлэн гурван алтан шүхрээ хатгаад бугаа шийрлэн замыг нь тосоод хэвтэнэ. “Нөгөө шулам авгай зуун алд зурман хөх чоно болчихсон харайлгаад ирж явна гэнэ. Яг аман хүзүүг нь барьж шагайж байгаад л буудаад орхижээ. Тэгтэл чоно ч байхгүй, авгай ч байхгүй болж гэнэ. Хурдалсаар хүрээд ирсэн чинь дундуураа хуга үсэрсэн хувхай сүүжний яс хоцорчээ” хэмээн төгсөнө. Буддын шашны ойголт бүхий бусад үлгэрт ихэвчлэн ном, уншлага, шашны холбогдолтой янз бүрийн эд зүйлийн тусламжтайгаар эсрэг дүрээ ялж байгаа бол энэ үлгэрт анчин залуу өөрөө догшин бурхдын дийлээгүй аюулт шуламсыг аман хүзүү дундуур нь буудан үгүй хийж байгаа өгүүлэмж бүхий ажээ.

Шашны агуулга бүхий шидэт үлгэр, баатарлагийн үлгэрт гол төлөв эхэнд нь мангастай тулалдаж буй сэдэв зонхилдог бол бусад шидэт үлгэрт ороолон, шулам мэтгэй тэрсэлдэж байгаа баатрын үйл явдалтай нягт холбоотой хоёр хэв шинжийн үлгэр байгаа нь ажиглагдаж байна.

Ийнхүү монгол ардын шидэт үлгэр агуулга, сэдвийн хувьд баяжсаар ирсэн нь нийгэм, цаг хугацааны өөрчлөлтийн асуудал бөгөөд судлаачдын тэмдэглэснээр буддын шашин сургаалын ном бүтээлүүд орчуулагдаж эхэлсэн XIII зууны үеэс шинэ мотив өгүүлэмж нэвтрэн жинхэнэ монгол ахуйд идээшиж, монгол сэтгэлгээгээр хувиран үндсэн монгол аман зохиолын жишээ мэт болсны гэрч юм.

Монгол ардын шидэт үлгэр ийнхүү сэдэв, агуулгын хувьд олон талтай түүхэн цаг хугацааны туршид өгүүлэмжийн болоод төрөл зүйл хоорондын хувьсалд орж шинэ сэдвээр сэлбэгдэн өөрчлөгдсөөр ирсэн байна. Ингэхдээ шидэт үлгэрийн уламжлалт өгүүлэмж мотивтой шинэ сэдэв сүлэлдэн олон хувилбарт үлгэр бий болсоор иржээ.

Монгол аман зохиолын бүх төрөл зүйл дүр, өгүүлэмж, мотивын төдийгүй янз бүрийн зан үйлээс илрэх жижиг элементүүдийн түвшинд домогзүйтэй холбогдох бөгөөд домогзүйн ухамсрын өөрчлөлт, хүний орчноо танин мэдэхүйн өсөлт, нийгмийн хөгжлийн хэрээр тэдгээрийн бүтцийн онцлог, уран сайхны илрэх арга барил мөн өөрчлөгдөн, шинэ хэлбэрийг олсоор иржээ.

Монгол аман зохиол судлалд бага хөндөгдсөн асуудлуудын нэг бол монгол ардын шидэт үлгэрийн нийгэм, ахуйн зөрчилт, баатарлагийн сэдэвт, домогзүйн холбогдолтой хийгээд шашны агуулга бүхий шидэт үлгэр хэмээн сэдэвчлэн ангилж мотив, өгүүлэмж, бүтэц, баатруудын нягт харилцаанд болон нийгэм түүхийн үүднээс өгүүлэмжийн бүрдэл хэсгийг тодруулах асуудал юм. Энэ асуудлыг тодруулан шидэт үлгэрт дүн шинжилгээ хийснээр түүний үндсэн гол, уламжлалт өгүүлэмжүүдийг томъёолж болох бөгөөд үлгэрийн өгүүлэмж хоорондын шилжилт, нийлэмжийг тодруулахад дөхөм болж өгнө. “Үлгэрийн өгүүлэмжүүд түүхэн хөгжлийн янз бүрийн үе шатанд өөрчлөгдсөөр ирдэг тул түүхэн зарчмыг анхааралдаа авах хэрэгтэй. Ямар цаг үед ямар өгүүлэмжүүд бий болсон, ямар түүхэн үйл явцыг хэрхэн тусгасныг тодруулахад мэдээж нэлээд эрт үед тооцогдох үлгэрийн эрдэм шинжилгээний цуглуулга, бичлэг байхгүйд хүндрэл оршдог” [Тудоровская, 1965, с. 59] хэмээн шидэт үлгэрийн ангиллын асуудлаар бичсэн өгүүлэлдээ оросын судлаач А.Е. Тудоровская тэмдэглэсэн байдаг. Монгол ардын шидэт үлгэр нийгмийн хөгжил, хувьслын хэрэрагуулга, сэдэв баяжсаар ирсэн бөгөөд домог үлгэрийн үндсэн мотив өгүүлэмж сонгодог шидэт үлгэрийн янз бүрийн элементүүдтэй сүлэлдэн өвөрмөц нэгэн шидэт үлгэр бий болж яригдсаар иржээ. Монголчуудын уламжлалт ертөнцийг үзэх үзэл, эртний ойлголтууд, зан үйлийн ул мөрүүд нь шидэт үлгэртээ тусгалаа олж түүний өгүүлэмжийн санг баяжууланулам олон талтай болгосон байна. “Домог үлгэрийн сэтгэлгээ нь орчлон ертөнцийн аливаа юм үзэгдлийн үүсэл гарал, учирзүйг танин мэдэж тайлбарлах гэснээрээ шинжлэх ухааны шинж чанартай, түүнийгээ уран сэтгэмжээрээ ургуулан бодож хийсвэр ойлголтыгтодорхой уран дүрээр илэрхийлснээрээ урлагийн шинжтэй, овгийн байгууллын үеийн хамт олны зааггүй нийлэг ухамсар, ертөнцийг үзэх үзлийг тусган илэрхийлж байна” [Сампилдэндэв, 2002, 8 т.].

Ном зүй

Гаадамба М., Цэрэнсодном Д. Монгол ардын аман зохиолын дээж бичиг // *Studia Folclorica* Tom.V, Fasc-1. 1967. Pp. 141-143.

Дамдинсүрэн Ц. Монгол уран зохиолын тойм. Боть 2. Улаанбаатар, 1977.

Сампилдэндэв Х. Монгол аман зохиолын товчоон. Улаанбаатар, 2002.

Сампилдэндэв Х. Монгол аман зохиолд бурхны шашны нөлөө туссан зарим асуудал // Монгол зан үйл, аман зохиолын харьцуулсан судалгаа. Улаанбаатар, 2004.

Тудоровская Е.А. О классификации волшебных сказок // *Советская этнография*. 1965. №2. С. 57-66.